



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 267

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,111,464,060.16 (нэг тэрбум нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга жаран төгрөг арван зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Баяндүүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005458  
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны..... дугаар сарын ...-ны өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Иж бүрдэл	Ашиглалтад орсон огноо	Дагалдах хэрэгслийн тоо, хэмжээ /ширхэг/	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ /төгрөг/	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	ICP Машин иж бүрдэл	Нууцлалтай түлхүүр	2012-07-16	514	257	4,324,762.88	1,111,464,060.16
		CF карт	2012-07-16	514			
		Уртасгагч залгуур	2012-07-16	257			
		Дүн мэдээ дамжуулах модем /GSM/, хувиргагч /CDMA/	2012-07-16	257			
НИЙТ ДҮН							
					257	4,324,762.88	1,111,464,060.16 (нэг тэрбум нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга жаран төгрөг арван зургаан мөнгө)